

БУРХАН БАГШИЙН СУРГААЛ БА ОРЧИН ҮЕ

Ж. Каламхас. Дархан – Уул аймаг. ТДС – ийн багш. Магистр

Түлхүүр үг: сансарын хүрд, дөрвөн үнэн, зөв үзэл, зөв сэтгэхүй, зөв үг, зөв үйл, зөв амьдрал, зөв тэмүүлэл, зөв дуртгал, зөв бясалгал.

Оршил. Хүн төрөлхтний соёлын томоохон өв сангийн нэг нь Бурхан багшийн сургаал юм. Их нигүүлсэгч бурхан багш хүн төрөлхтөнд хамаг сайн сайхныг авчирч агуу их сургаал номыг бий болгож, түүнийг үеэс үед шавь нар нь түгээн дэлгэрүүлж ирсэн түүхтэй.

Өнөөгийн нийгэмд Бурхан багш болон түүний шавь нарын зохиож, туурвисан дээдийн номын учир утгыг ард түмэн, нэн ялангуяа залуу үедээ уламжлуулан ойлгуулж, ухамсарлуулах нь хамгийн чухал зүйлийн нэг болоод байна. Учир нь бурхан багшийн сургаал бол ёс суртахууны эерэг зан байдлын тухай сургаал юм. Ийм сургаал бидэнд ихээхэн үгүйлэгдэж байна.

Орчин үед ёс суртахуунт зан чанар гэж юу болох, түүний үндэс нь юу болох тухай асуудал өдөр ирэх тусам учир утгаа алдаж, тэр хэмжээгээр нийгэмд айдас, түгшүүр, үл итгэх байдал, элдэв дарамт, хүнлэг бус, шударга бус байдал алдагдаж, хүмүүсийн харилцаа хүйтэн хөндий болж байгаа нь олон сөрөг үр дагавар, бэрхшээл учруулах боллоо. Ийм нөхцөл байдлыг засч залруулахад бурхан багшийн сургаалаас бидэнд сурч мэдэх зүйл их бий.

Бурхан багшийн сургаалийн гол агуулга, зохиол бүтээлийг эдүгээчлэн ойлгож, тайлбарлан таниулах хэрэгцээ шаардлага өсч буй. Учир нь бурхан багшийн сургаалд Хүнийг хамгийн эрхэм дээд гэж үздэг бөгөөд “Хүн өөрөө өөрийн итгэл /аврал / мөн. Хүн өөрийн чармайлт, оюун ухаанаараа элдэв хүлээснээс өөрийгөө ангижруулах чадалтай байдаг тул өөрийгөө хөгжүүлж, аливаа дарамтаас ангижирч чадна хэмээн сургасан буй. Мөн “Хүнийг чөлөөлнө гэдэг хүн өөрөө Үнэний сургаалийг хэрхэн ухааран хэрэгжүүлснээс шууд хамаарахаас бус, харин эрхэт тэнгэр буюу аливаа нэг гадны хүчинд дуулгавартай шүтэж байсны төлөө шан болгож хайрласан энэрэл ивээл гэгчээс үл хамаарах үйл юм.

Будда, Бурхан багш хэмээн алдаршсан эртний Энэтхэгийн Шагха язгууртны хүү Сиддхарта Гаутамагийн сургаалийг дагадаг хүмүүсийг Бурханы шашинтан гэж хэлдэг. Тэрээр 2500 гаруй жилийн өмнө Энэтхэгт амьдарч байв. Буддын шашинтнууд түүний сургаалийг амьдралынхаа зарчим, ертөнцийг үзэх үзлээ болгодог. Энэхүү итгэл үнэмшлээ тэд дээдийн ном буюу dharma, Buddha-dharma буюу Бурхан багшийн үнэн сургаал хэмээн үздэг. Бурхан багшийн анхны шавь нарын зарим нь Энэтхэг болон бусад улс орноор аялж дээдийн номыг түгээсэн байна. Энэхүү бусдад энэрэнгүй, нигүүлсэнгүй сэтгэлээр хандах үнэн сургаалийг эдүгээ манай дэлхийн асар олон хүн дагадаг.

Бурхан багшийн сургаалд тэмдэглэснээр, “Буянаар нүглийг дарж үйлд. Өглөгөөр хармыг дарж үйлд. Үнэнээр худлыг дарж үйлд. Ялах,

ялагдахыг орхивоос амгалан жаргаланд учирна. Зөвхөн өөрөө өөрийгөө байлдан дагуулах нь л аз жаргал буй болгоно".



Сансарын хүрд. Сансар нь үхэх, төрөх буюу дахин дахин үхэж төрөхийн эцэс төгсгөлгүй эргүүлэг, тойргийг илэрхийлдэг. Хүрдний захын гинжин хэлхээнд хүний амьдралыг харуулжээ. Бид алинд нь төрж болох юм. Хүрдний голд буй гурван амьтан хүсэл, шунал, уур хилэн, тэнэг мунхагийг төлөөлдөг. Тэд хүний гэгээрэх замд саад болдог. Хэрэв хүн гэгээрч эс чадваас энэхүү тойрогт байнга эргэлдэх тавилантай юм.

Дөрвөн үнэн. Бурхан багшийн сургаалийн нэг гол үзэл баримтлал нь дөрвөн үнэний тухай сургаал юм. Үүнд:

1. Анхдахь үнэн бол зовлон юм.
2. Хоёрдахь үнэн бол зовлон гарахуй юм.
3. Гуравдахь үнэн бол зовлонгоос ангижрахуй юм.
4. Дөрөвдэх үнэн бол зовлонгоос гэтлэх арга зам юм. Энэ нь найман зөв зам мөр


болно. Найман зөв зам мөр нь бие хэл сэтгэлийн хувьд хүн өөрийгөө журамлах, өөрөө өөрийгөө хөгжүүлэх арга зам юм.

Хэмжээ хязгааргүй баян тансаг амьдрал, эсвэл хүнд хэцүү ядуу амьдралын аль нь ч аз жаргалыг хүмүүст өгч чадахгүйг Будда өөрийн туршлагаар таньж мэдсэн байна. Тэгээд зөв амьдрах дундад зам мөрийн сургаалийг тэрбээр хүмүүст номложээ. Дундад зам мөрийг дагасан хүмүүс шунал, хүслийн хүлээснээс ангижирч, амьдралаас илүү ихийг хүсэхээ больж, зовлон зүдгүүрээ гэтлэн гэгээрэлд хүрэхийг эрмэлздэг ажээ. Түүнчлэн хүний амьдралын сайн, муу байх нь зөвхөн хувь хүнээс өөрөөс шалтгаалдаг болохыг Бурхан багш зааж сургажээ. Түүний сургаал хүмүүст амьдралын мөн чанарыг ухаарахад туслахад чиглэсэн юм.

Дундаж зам ("төв үзэл" гэж хэлдэг) мөрийг бас найман зөв зам гэж нэрлэдэг. Хүрдний хигээсүүд найман зөв замаар явах үе шатыг билэгддэг. Нэг хигээстэй хүрд эргэхгүйтэй адилаар найман зөв зам мөрийг бид бүгдийг

адилхан мөрдөж байж, улмаар Бурхан багшийн сургаалийг амьдралдаа дагаж хэрэгжүүлж сайн сайхан амьдарч чадна. Үүнд:

1. Зөв үзэл нь юмсыг яг байгаагаар нь ухаарахуй юм.
2. Зөв сэтгэхүй нь Би-гээс ангижрахуй, энэрэн нигүүлсэх үзэл сэтгэлгээ юм.
3. Зөв үг нь: Худал хэлэх, бусдыг ил далд муулж, гүтгэх, хов ярих, хоосон чалчаа үг, ширүүн бүдүүлэг үг хэлэх, хараалын үг хэрэглэхийг цээрлэх явдал юм. Ийм байж чадсанаар хүн үнэнийг өгүүлэх, нөхөрсөг, эелдэг,



утга төгөлдөр хэрэгцээт үгийг хэрэглэнэ.

4.Зөв үйл нь ёс суртахуунлаг, төв шударга, энх амгалан амьдрах явдал юм.

5.Зөв амьдрал нь бусдыг болон өөрийгөө зовлонд унагахгүй байх, гэм хор хүргэхгүй амьдрах хэрэгтэй гэсэн үг юм.

6.Зөв чармайлт тэмүүлэл нь аливаа үйлийг бодолтойгоор хийх, нүгэлт болон ариун бус бодол сэтгэл үүсэхээс болгоомжлон хорих, буянт сэтгэлийг өөртөө хөгжүүлэх чармайлт юм.


7.Зөв дуртгал нь хүний сэтгэл, үзэл бодол, үйл хэрэгтээ анхааралтай хянамгай байхыг чухалчлах гэсэн үг.

8.Зөв бясалгал нь оюун ухаанаа төвлөрүүлэх замаар элдэв муу хүсэл шуналаас бүрмөсөн ангижрах явдал юм. Эдгээр найман зам мөр нь харилцан холбоотой бөгөөд нэг нь нөгөөгөө хөгжүүлэхэд тусалдаг.

Энэ бүхнээс үзвэл, бурхан багшийн сургаал нь бүхэлдээ хүч үл хэрэглэх, амгалан тайван байх, энэрэнгүй нигүүлсэнгүй байх, өгөөмөр сэтгэлтэй, өглөгч буянтай байх, ёсыг барих, үзэн ядах болон өшиж хорсохыг цээрлэх, тэсвэр тэвчээртэй, ухаалаг амьдрах тухай сургаал юм.

Судалгааны объект

Дархан-Уул аймгийн Дархан сумын 22620 иргэнд судалгаа хийсэн.



Зорилго

Судалгааны ажлын гол зорилго нь Бурхан багшийн сургааль бидний амьдралд яаж хэрэгжиж байгаа болон түүний мөн чанарыг бид хэрхэн ойлгож ухаарч, амьдралдаа мөрдлөг болгож чадаж байгааг тодорхойлох явдал юм.

Бурхан багшийн сургаалийн талаарх хүмүүсийн төсөөлөл

Дархан-Уул аймгийн Дархан сумын хүн амыг бүрдүүлж байгаа 22620 хүнд хийсэн судалгааны 61% буюу ихэнхи хэсэг нь Буддын шашин шүтдэг хүмүүс эзэлсэн байна.

Шашин шүтэж, даган баримтлана гэдэг нь сүм хийдэд амьдрах, ном залбирал унших /уншуулах/ зэрэг гадаад төрхөөр биш, харин түүнийг үнэн

сэтгэлээсээ хүлээн авч сүсэглэн, сургаал номлолыг нь хэрхэн даган мөрдөж байгааг мэдэхийн тулд дараах асуултыг тавьсан.

Хэрвээ та буддын шашин шүтдэг бол ямар хэлбэрээр илүү шүтдэг вэ? гэсэн асуултанд хариулсан байдлыг үндэслэн дүгнэн үзвэл, 1/6 /хариулт болох засал хийлгэж, ном уншуулах нь 60% буюу дийлэнхи хэсгийг эзлэж байна.

Бурханы сургаалиас суралцан, түүнийгээ амьдралдаа хэрхэн хэрэгжүүлж, эрээд байгаа жаргалдаа хэрхэн хүрч байгааг мэдэх зорилгоор дараах асуултуудыг тавьсан. Бурхан багшийн сургаалийн талаар хэр мэдлэгтэй вэ? гэсэн асуултанд нийт оролцогчдийн 39%-бага зэрэг, 25%-огт мэдэхгүй, 24 %-дунд зэрэг, 12%-мэднэ гэж хариулсанаас үзвэл, Бурхан багшийн сургаалийг тэр бүр сайн мэддэггүй бөгөөд амьдралдаа мөрдлөг болгоод байдаггүй нь харагдаж байна.

Дээрхи асуултыг гүнзгийрүүлэн бататгах зорилгоор Бурхан багшийн сургаалиас бичнэ үү? Гэсэн асуулт тавихад 90 гаруй хувь нь огт хариулаагүй байлаа. Зарим хүмүүс нь арван хар нүгэл, арван цагаан буян, сайн үйл хийвэл хойд төрөлдөө сайн, муу үйл бүтээж болохгүй, архиа бага ууж, айргаа их уу, энэрэл нигүүлсэх тухай гэх мэг хариултыг өгсөн нь ард түмний дунд дахь Бурхан багшийн сургаалийн талаархи ойлголт ерөнхий агуулгыг нь бүрэн дүүрэн мэдэхгүй байгааг илтгэж байна. Дээрх судалгааны үр дүнг зураг1 -д харуулсан болно.

Бурхан багшийн сургаалийг дэлгэрүүлэх арга зам

Эдүгээ шинжлэх ухаан, техник технологийн үсрэнгүй хөгжлийн үетэй зэрэгцэн хүний хөгжлийн үйл явц нь гадаад бие махбод биологийн хөгжлийг илүүд авч үзэж, дотоод ухамсар, оюун санааны хөгжлийн тухай харьцангуй бага ярьж, бичиж байгаа нь нэн харамсалтай. Оюун ухааны болон сэтгэл санааны талаархи мэдлэгийн хөгжил туйлаас хоцрогдсон гэсэн яриа ард түмний дундаас мэр сэр сонсогдох болсонтой холбогдуулан дараах асуулгын судалгааг хийсэн. Өнөөгийн нийгэмд Бурхан багшийн сургаалийг дэлгэрүүлэх шаардлагатай юу? гэсэн асуултанд нийт оролцогсдын 62 хувь буюу 14025 хүн шаардлагатай гэж хариулсанаас үзвэл, цаашдаа бид Бурхан багшийн сургаалийг түгээн дэлгэрүүлэхийн чухлыг сануулж буй том жишээ юм.

Бурхан багшийн сургаалийг дэлгэрүүлэхийн ач тус.асуултанд 43% /9730/ нь хүн болж төлөвших /эрдэнэт хүний биеийг олох /, 30% /6788/ нь амьдралын мөн чанарыг ухаарах гэж хариулсан.

Ер нь Бурханы номыг хүндэтгэн дагахын шалтгаан нь материаллаг эд баялаг хэдий арвин байлаа ч тэр нь дангаараа бүрэн дүүрэн, урт удаан хугацааны амар амгаланг өгч чадахгүйд оршино.

Ямар арга замаар Бурхан багшийн сургаалийг дэлгэрүүлбэл ард түмэнд илүү хүртээмжтэй гэж бодож байна вэ? гэсэн санал асуулгад 28%/6336/ Буддын шашны төв байгуулах/ сургалт/,26%/5875/ телевиз радио нэвтрүүлэг, 23%/5204/ ном тараах материал, 23%/5205/ лекц унших. Бурхан багшийн сургаалийг дэлгэрүүлэх тал дээр олон арга хэмжээ авч байгаа хэдий ч хариулсан байдлаас үзвэл, Дархан-Уул аймгийн Дархан суманд нийт шашны 28 сүм, хийд, байгууллага байдгаас Буддын сүм - 8, Христийн сүм -17, Мусламаны төв -1, Бахайн шашны төв -1, Бөөгийн шашны төв-1 бүртгэлтэй байна.

Иймээс төрөлхтөн болгон өөр зан авиртай, оюуны чадамж адилгүй байдаг тул тус бүрт тохирох аргуудыг хэрэглэн номловоос Бурхан багшийн сургаалийг хүн болгон мөрдөж чадах боломжтой гэсэн дүгнэлт хийж байна. Дээрх судалгааны үр дүнг зураг 2 –д харуулсан болно.

2. Бурхан багшийн сургаалийн талаарх хүмүүсийн төсөөлөл

1. Та хэдэн настай вэ?

а. 18с доош б. 18-30

в. 30-45

г. 45с дээш

2. Та ямар шашин шүтдэг вэ?

а. Будда

б. Христ

в. Муслам

г. Шашин шүтдэггүй

3. Хэрвээ та буддын шашин шүтдэг бол ямар хэлбэрээр илүү шүтдэг вэ?

а. Бурхан багшийн сургаалийг амьдралдаа хэрхэн хэрэгжүүлдэг вэ?

б. Засал хийлгэж, ном уншуулах

в. Суврага, шүтээн тахиx




4. Бурхан багшийн сургаалийн талаар хэр мэдлэгтэй вэ?

а. мэднэ

б. дунд зэрэг

в. бага зэрэг г. мэдэхгүй

5. Бурхан багшийн сургаалиас бичнэ үү?



Зураг 1

3. Бурхан багшийн сургаалийг дэлгэрүүлэх арга зам

1. Өнөөгийн нийгэмд Бурхан багшийн сургаалийг дэлгэрүүлэх шаардлагатай юу?





- а. Шаардлагатай б. Шаардлагагүй
в. Мэдэхгүй

2. Бурхан багшийн сургаалийг дэлгэрүүлэхийн ач тус юунд орших вэ?

- а. Амьдралын мөн чанарыг ухаарах
б. Хүн болж төлөвших/ эрдэнэт хүний биеийг олох/
в. Ёс суртахууны үнэлэмжтэй болох
г. Харилцааны соёлын тодорхой түвшинтэй болох
д.
е.

3. Ямар арга замаар Бурхан багшийн сургаалийг дэлгэрүүлбэл ард түмэнд илүү хүртээмжтэй гэж бодож байна вэ?

- а. Телевиз, радио нэвтрүүлэг б. Лекц унших
в. Ном тараах материал
г. Буддын шашны төв байгуулах /сургалт/
.....
.....



Зураг 2

Дүгнэлт

Энэхүү бяцхан судалгааны дүнгээс үзэхэд, манай Дархан-Уул аймгийн хүн амын дотор бурхан багшийн сургаалийн талаархи мэдлэг хомс байгаа нь хүнлэг бус үйлдэл үйл ажиллагаа ихээхэн газар авч, энэрэн нигүүлсэх үзэл алдагдахад нөлөөлж буй нэг хүчин зүйл болж байна.

Ийм учраас Монголчуудын түүх, оюуны соёлын үнэтэй өв болох буддын шашны хүрээнд уламжлагдан ирсэн ёс заншил, үзэл сургаалыг ард иргэд, хүүхэд залуучуудад таниулах, тэдэнд хүнлэг энэрэнгүй сургаалийн гүн утгыг ухааруулахын тулд бид цаашид бурхан багшийн сургаалийг үнэн зөвөөр түгээн дэлгэрүүлэх нь чухал. Үүнд:

1. Бурхан багшийн сургааль дахь оюуны үнэ цэнэ, агуулга цар хүрээг үнэн бодитой, түүнчлэн одоо цаг үетэйгээ холбон судлаж, хүүхэд залуучуудад сурталчилах ажлыг шинэ шатанд гаргах хэрэгтэй байна.
2. Энэхүү үйл хэрэгт шашин судлалын чиглэлээр мэргэшин гарч байгаа төгсөгчдийг өргөн оролцуулж байх нь зүйтэй.
3. Буддын шашин бол уламжлалт соёл мэдлэг ухааныг түгээн дэлгэрүүлэх баялаг өв сантай бөгөөд хамгийн оюунлиг, энэрэнгүй шашин билээ. Иймд бүх шатны сургуульд энэ талаар сургалтын хөтөлбөр боловсруулж, хичээл заах хүүхэд залууст аль болох багаас нь энэрэн нигүүлсэх үзэл сэтгэлгээг төлөвшүүлэх нь хүмүүнлэг иргэний ардчилсан нийгэм байгуулах нэг үндсэн нөхцөл болно гэж үзэж байна.

Сэтгэлийн хөгжил гэгээрэл нь хүний жинхэнэ хөгжил буй за.

Ном зүй

- Анита Ганери "Бурхны шашны тухай" УБ., 2004
Бурхан багшийн сургаал .УБ.,1996
Ш.Ганхуяг, М.Гантуяа. Философийн түүхэн тойм. УБ., 2002
Р.Дарьхүү, Г.Эрдэнэбаяр "Философийн түүх" УБ., 2006
Дээрхийн гэгээнтэн 14-р далай лам "Сэтгэлийн амирлал" УБ., 2003.
Түвдэн Ешэ Лам "Төвдийн бурхны шашны мөн чанар" УБ., 2003.
"Философи эхлэн суралцах бичиг" УБ., 2001.
"Энэрэн нигүүлсэх бурхны сургаал" УБ., 1991.